



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/17/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: <a href="mailto:Gereltekhhburtgelaudit02@gmail.com">Gereltekhhburtgelaudit02@gmail.com</a> Ахлах аудитор: Д.Галт-Эрдэнэ Утас: 80085430 Цахим хаяг: <a href="mailto:Gereltekhhburtgelaudit02@gmail.com">Gereltekhhburtgelaudit02@gmail.com</a> Аудитор С.Дашдэндэв Утас: 80099418 Цахим хаяг: <a href="mailto:Gereltekhhburtgelaudit02@gmail.com">Gereltekhhburtgelaudit02@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠑᠔2᠕. ᠐᠓.᠒᠑ № 477

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН  
ХАНГАМЖИЙН УДИРДАХ ГАЗАР  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Г.БАТТУЛГА ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ нь тайлант онд 23 байгууламжийн 22 нүүрс, хийн зуух, 1 станц, 79 халаалтын зуухаар 49,750.2 гкал/ц дулааны эрчим хүч үйлдвэрлэн 736 айл өрх, 127 аж ахуйн нэгж, байгууллагуудыг дулааны эрчим хүчээр ханган ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанээс үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	604,167,737.55	802,690,460.18
1.1.2	Дансны авлага	54,169,646.06	70,768,883.04
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	5,221,722.05	27,982,907.31
1.1.6	Бараа материал	805,388,560.74	1,101,755,903.89
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	290,757,134.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,468,947,666.40</b>	<b>2,293,955,288.42</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,944,865,202.78	12,717,203,981.97
1.2.2	Биет бус хөрөнгө	422,77,877.64	421,866,518.34
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,581,597,129.50	0.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>13,949,440,209.92</b>	<b>13,139,070,500.31</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,418,387,876.32</b>	<b>15,433,025,788.73</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,781,387.89	7,447,778.89
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,781,387.89</b>	<b>7,447,778.89</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	3,581,597,129.50
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,781,387.89</b>	<b>3,581,597,129.50</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,781,387.89</b>	<b>3,589,044,908.39</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	1,097,218,307.26	1,097,218,307.26
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	18,051,767,253.05	14,470,170,123.55
2.3.5	Хуримтлагдсан ашиг	(4,369,453,073.27)	(4,360,481,551.86)
2.3.5.1	Тайлангийн үеийн ашиг	(583,542,203.84)	8,971,521.41
2.3.5.2	Өмнөх үеийн ашиг	(3,785,910,869.43)	(4,369,453,073.27)
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	637,074,001.39	637,074,001.39
<b>2.3.6</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>15,416,606,488.43</b>	<b>11,843,980,880.34</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,418,387,786.32</b>	<b>15,433,025,788.73</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>3,519,060,714.07</b>	<b>5,088,953,255.61</b>
2	Борлуулалтын өртөг	5,593,871,764.06	6,972,230,481.03
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(2,074,811,049.99)</b>	<b>(1,883,277,225.42)</b>
5	Хүүгийн орлого	-	11,181,785.54
8	Бусад орлого	2,670,658,934.00	3,805,649,668.29
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,020,943,060.70	1,761,582,979.85
12	Бусад зардал	67,086.472.60	3,010,000.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(91,360,554.55)	(158,871,548.60)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(583,543,203.84)</b>	<b>10,089,699.96</b>
19	Орлогын татварын зардал	0.00	1,118,178.55
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(583,543,203.84)</b>	<b>8,971,521.41</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-

**“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	(583,543,203.84)	8,971,521.41
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(583,543,203.84)	8,971,521.41
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,966,954,319.55	(3,785,910,869.43)	12,915,335,758.77
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,966,954,319.55	(3,785,910,869.43)	12,915,335,758.77
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(583,542,203.84)	(583,542,203.84)
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	3,084,812,933.50	-	3,084,812,933.50
7	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	18,051,767,253.05	(4,369,453,073.27)	15,416,606,488.43
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	18,051,767,253.05	(4,369,453,073.27)	15,416,606,488.43
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	8,971,521.41	8,971,521.41
11	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(3,581,597,129.50)	-	(3,581,597,129.50)
13	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,097,218,307.26	637,074,001.39	14,470,170,123.55	(4,360,481,551.86)	11,843,980,880.34

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>6,625,304,422.70</b>	<b>9,520,664,115.73</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,954,645,488.70	6,848,707,164.73
	Бусад мөнгөн орлого	2,670,658,934.00	2,671,956,951.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>6,421,930,023.68</b>	<b>9,333,323,178.64</b>
	Ажиллагчдад төлсөн	1,124,201,438.85	1,565,943,031.32
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	510,034,440.07	696,757,345.98
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,475,839,060.71	6,430,835,226.22
	Ашиглалтын зардалд төлсөн	8,132,377.00	2,493,930.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,164,400.00	782,700.00
	Татварын байгууллагад төлсөн	161,130,998.37	421,165,541.32
	Даатгалын төлбөрт төлсөн	590,624.00	4,900,000.00
	Бусад мөнгөн зарлага	125,836,684.68	210,445,403.80

**“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	203,374,399.02	187,340,937.09
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	11,181,785.54
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	11,181,785.54
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	11,181,785.54
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	203,374,399.02	198,522,722.63
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	400,793,338.53	604,167,737.55
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	604,167,737.55	802,690,460.18

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2022 он	2023 он		Өсөлт/+/- бууралт /-/	
		Гүйцэтгэл	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зөрүү/+,-/
Халаалтын орлого	3,529,228,610.00	5,544,013,000.00	5,088,953,255.61	(455,059,744.39)	(8.2)
Төсвийн санхүүжилт	2,664,261,742.00	2,664,261,700.00	2,664,261,700.00	-	-
Бусад	6,397,265.00	8,000,000.00	1,152,569,744.39	1,144,569,744.39	14.407.1
<b>Нийт орлого</b>	<b>6,199,887,617.00</b>	<b>8,216,274,700.00</b>	<b>8,905,784,700.00</b>	689,510,000.00	<b>8.4</b>
<b>Өртөг, зардал</b>				-	
Түлш	2,533,081,000.00	2,392,919,102.00	2,571,415,903.00	178,496,801.00	7.5
Хийн түлш		1,186,915,380.00	684,065,107.00	(502,850,273.00)	(42.4)
Цахилгаан	378,015,515.00	357,098,000.00	471,428,945.00	114,330,945.00	32.0
Технологийн ус	81,460,632.00	159,182,040.00	118,668,214.00	(40,513,826.00)	(25.5)
Сэлбэг хэрэгсэл, урсгал засвар	236,455,412.00	240,380,000.00	550,340,460.00	309,960,460.00	128.9
Үндсэн ба нэмэгдэл цалин	2,053,967,368.00	2,430,877,316.00	2,781,781,326.00	350,904,010.00	14.4
Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	277,803,301.00	328,168,422.00	382,039,704.00	53,871,282.00	16.4
Хог хаягдал, цэвэрлэгээ	70,132,903.00	97,266,667.00	96,812,264.00	(454,403.00)	(0.5)
Бичиг хэрэг	7,170,645.00	10,930,000.00	8,217,936.00	(2,712,064.00)	(24.8)
Харилцаа холбоо, интернэт	8,355,906.00	9,255,000.00	5,746,317.00	(3,508,683.00)	(37.9)
Хөдөлмөр хамгаалал	131,764,475.00	71,148,803.00	69,785,622.00	(1,363,181.00)	(1.9)
Элэгдэл	630,523,803.00	668,000,000.00	668,000,000.00	-	-
Ашиглалтын зардал	11,415,241.00	18,770,000.00	17,986,574.00	(783,426.00)	(4.2)
Шатахууны зардал	49,960,416.00	87,599,000.00	70,949,803.00	(16,649,197.00)	(19.0)
Томилолт		15,000,000.00		(15,000,000.00)	(100.0)
Сургалтын зардал	6,462,646.00	15,000,000.00	9,216,552.00	(5,783,448.00)	(38.6)
Зохицуулах үйлчилгээний хөлс	7,594,224.00	10,500,000.00	3,500,647.00	(6,999,353.00)	(66.7)
Гадны үйлчилгээний хөлс	5,500,000.00	5,500,000.00	5,500,000.00	-	-
Аваарын үеийн эрсдэлийн нөөц сан	18,500,000.00	10,767,000.00	10,000,000.00	(767,000.00)	(7.1)
Бусад зардал	238,841,000.00	39,700,000.00	319,036,477.00	279,336,477.00	703.6

**“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

Газрын төлбөр	3,820,546.00	5,000,000.00	5,000,000.00	-	-
ҮХХАТ	13,624,876.00	14,000,000.00	14,000,000.00	-	-
АТӨЯХАТ	914,132.00	2,000,000.00	1,923,642.00	(76,358.00)	(3.8)
Банкны шимтгэл	286,799.00	300,000.00	300,000.00	-	-
Ажиллагсдын нийгмийн зардал	17,778,980.84	39,997,970.00	29,979,507.04	(10,018,462.96)	(25.1)
<b>Өртөг, зардлын дүн</b>	<b>6,783,429,820.84</b>	<b>8,216,274,700.00</b>	<b>8,895,695,000.04</b>	<b>679,420,300.04</b>	<b>8.3</b>
Татвар төлөхийн өмнөх ашиг	(583,542,203.84)	-	10,089,699.96		
Орлогын албан татвар	-		1,118,178.55	1,118,178.55	
Цэвэр ашиг, алдагдал	<b>(583,542,203.84)</b>	-	<b>8,971,521.41</b>		
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.00	1.00	1.00	-	-
Нийт авлага	59,391,300.00	600,000,000.00	98,751,790.35	(501,248,209.65)	64.6
Нийт өр төлбөр	-	500,000.00	7,447,778.89	6,947,778.89	1,389.5
Нийт хөрөнгө оруулалт	41,073,500.00	50,000,000.00	49,600,000.00	(400,000.00)	(0.8)
Худалдан авалт	41,073,500.00	50,000,000.00	49,600,000.00	(400,000.00)	(0.8)

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 3,581,597.1 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Үнэ төлбөргүй шилжин ирсэн 3,581,597.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг үндсэн хөрөнгө болон хойшлогдсон орлого дансанд бүртгэж, толилуулаагүй, дуусаагүй барилга дансанд бүртгэж, санхүүгийн тайланд бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд тайлагнаж, хөрөнгө ашиглалтгүй байна. Энэ нь байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 2 дугаар бүлгийн 2.2.7 болон "Аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүйгээр буюу буцалтгүй тусламж, бэлэг, хандиваар үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэн бол хүлээн авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлант үеийн орлого/хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрнө", НББОУС 20-ын "Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж"-д заасан аргуудаас сонгон хэрэглэж болно" заалт, Засгийн газрын туслалцаа, буцалтгүй тусламж НБББОУС 20-ийн "Хөрөнгөтэй холбоотой буцалтгүй тусламж" хэсэгт тодорхойлсон "Бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус буцалтгүй тусламжийг багтаасан хөрөнгөтэй холбоотой Засгийн газрын буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого хэлбэрээр эсвэл ,, хэлбэрийн аль нэгээр балансад толилуулна", "буцалтгүй тусламжийг хойшлогдсон орлого болгох ба тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэй, ул үндэслэлтэй сууриар орлого гэж хүлээн зөвшөөрөх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 29,915.1 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс 7,552.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22,362.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 29,915.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 105,550.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 183/ШШ2022/00657 дугаар бүхий шийдвэрээр эргүүлэн тогтоолгосон 1 ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, хөлстэй тэнцэх олговор олгохоор шийдвэрлэж, "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагад даалгасан бөгөөд буруу шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлэлгүй, ХИХУГ-ын Хаан банкны 5040031615 дугаар харилцах

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

данснаас 7,552.9 мянган төгрөгийг олгосон байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4 заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулан бол гэм хорыг арилган байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхтэй", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Авлагын дансанд 2015 онд үүссэн Голден файл фин ХХК-аас авах 8 жилийн насжилттай 2,100.0 мянган төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас авах 2022 онд үүссэн 4,293.5 мянган төгрөгийн, Их аян сүлд ХХК-аас авах 7 жилийн насжилттай 15,968.7 мянган төгрөгийн, нийт 22,362.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагатай, байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,," заалт, мөн хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, он дамжсан хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлын хэсэг томилон шат дараатай үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлагыг барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө болон хойшлогдсон орлого дансанд бүртгэж, толилуулаагүй	1	3,581,597.1	-	-	1	3,581,597.1	1	3,581,597.1	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,581,597.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,581,597.1</b>	<b>1</b>	<b>3,581,597.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс					
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Буруу шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтан	1	7,552.9	1	7,552.9	-	-	-	-	-	-	-	-
Хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагатай	1	22,362.2	-	-	-	-	1	22,362.2	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>29,915.1</b>	<b>1</b>	<b>7,552.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>22,362.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	1,454,025.3	-	-	1	1,454,025.3	-	-	-	-	-	-

**“Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,454,025.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,454,025.3</b>	<b>-</b>	<b>-</b>
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Нийт ажилчдад урамшуулал олгохдоо ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлээгүй	1	29,989.2	-	-	1	29,989.2	-	-
Ашиглагдахгүй он удаан жил болсон хөрөнгө бүртгэлтэй	1	26,977.2	-	-	-	-	1	26,977.1
Автомашинны улсын дугаарт цэнхэр дэвсгэр аваагүй	1	-	-	-	-	-	1	-
Дулааны тоолуур ашиглаж, хэмнэлтийн горимд шилжүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>56,966.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>29,989.2</b>	<b>3</b>	<b>26,977.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>1,510,991.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,484,014.5</b>	<b>3</b>	<b>26,977.1</b>